

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД
ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

2024 оны 06 дугаар сарын 14

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2020 оны 217 дугаар

тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд явцын хяналт-шинжилгээ хийж, дүнг танилцуулж байна.

Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний хагас жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл **81.4** хувьтай байна.

Биелэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

Арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь						Дундаж хувь
	/-/	0	30	50	70	90-100	
24	3	1	2	1	3	14	81,4

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

Д/д	№	Арга хэмжээ	Үнэлгээ	Үнэлгээний тайлбар
1	2.3	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia, e-business/-аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	50	Эрчимжүүлэх шаардлагатай. Тайлагналт хангалтгүй /e-business үйлчилгээний тоог тайлагнах/
2	3.4	Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх	30	Эрчимжүүлэх шаардлагатай. шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах /эрсдлийг бууруулсан тоо/
3	5.1	Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	0	Үр дүнгүй. Гадаад сургалт төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

4	6.1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	30	<p>Эрчимжүүлэх шаардлагатай. Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах. Сурталчилсан үйл ажиллагаа, зохион байгуулсан арга хэмжээг өөр арга хэмжээгээр тайлагнасан /гэр бүлдээ гэрэл нэмье, тэр бум мод гэх мэт/</p>
---	-----	---	----	--

Зөвлөмж, цаашид анхаарах асуудлууд

1. Гүйцэтгэлийн тайланг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу тайлагнахдаа иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, тодорхой, товч байх гэсэн нийтлэг шаардлагыг баримтлах. *(тайлангийн хүснэгтэд хугацаа гэсэн эгнээ илүү, хянасан, тайлагнасан албан хаагчийн бүрдэл дутуу);*
2. Тайлагналтыг шалгуур үзүүлэлтээр илэрхийлсэн тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан, зорилтот түвшний тусгал байхаар тайлагнах; Тухайлбал: 2.3 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй e-business үйлчилгээний тоог тайлагнаагүй, үр дүн хэрэгжилт нь зорилтот түвшинд хүрээгүй, 6.1 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа цахим хуудас нийгмийн сүлжээнд байршуулсан мэдээллийн холбоосыг дурдаж тайлагнах, хамааралгүй арга хэмжээг тайлагнасан байна.
3. Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг ямагт харгалзан үзэж тайлагнахыг анхаарах; */шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж тайлагнаагүй нь үнэлгээ алдах гол үзүүлэлт болж байна./*
4. Эхний хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжиж дуусаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дуусгах, жилийн турш төлөвлөсөн хэрэгжилт удаашралтай, хангалтгүй, тасарсан арга хэмжээнүүдийг эрчимжүүлж, гүйцэтгэлийг сайжруулах зэрэг болно.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР